※ 번역문은 민원 신청을 위한 참고용이며, 기존의 한글 서식에 한글로 작성하여 제출해야 함을 유의해주시기 바랍니다.
※ Энэхүү орчуулга нь зөвхөн лавлах зориулалттай бөгөөд та солонгос хэл дээрх маягтыг зөвхөн солонгос хэлээр бөглөж ирүүлэх шаардлагатайг анхаарна уу.

■ 부동산 거래신고 등에 관한 법률 시행규칙 [별지 제1호서식] <개정 2023. 8. 22.>
■ Үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам [Хавсралтын 1-р маягт] <2023 оны 8-р сарын 22-ны өдөр шинэчлэгдсэн>

부동산거래관리시스템(rtms.molit.go.kr) 에서도 신청할 수 있습니다.
Үл хөдлөх хөрөнгийн арилжааны удирдлагын систем (rtms.molit.go.kr)-с хүсэлт гаргаж болно.

부동산거래계약 신고서
Үл хөдлөх хөрөнгийн арилжааны гэрээний мэдүүлэг

※ 뒤쪽의 유의사항·작성방법을 읽고 작성하시기 바라며, [ ]에는 해당하는 곳에 √표를 합니다. (앞쪽)
※ Ард талд байгаа анхаарах зүйлстэй сайтар танилцсаны дараа [ ]-д хамаарах хэсэгт √ тэмдэглэнэ үү. (Урд тал)

접수번호 Хүлээн авсан бүртгэлийн дугаар	접수일시 Хүлээн авч бүртгэсэн өдөр цаг	처리기간 Шийдвэрлэх хугацаа	지체없이 хойшлуулахгүйгээр

① 매도인 ① Худалдагч	성명(법인명) Овог нэр (Хуулийн этгээдийн нэр)	주민등록번호 (법인·외국인등록번호) Регистрийн дугаар (Хуулийн этгээд / гадаад иргэний бүртгэлийн дугаар)	국적 Иргэншил	
	주소(법인소재지) Хаяг (Хуулийн этгээдийн бүртгэлтэй хаяг)		거래지분 비율 Арилжааны эзлэх хувийн харьцаа (분의) (/)	
	전화번호 Утасны дугаар	휴대전화번호 Гар утасны дугаар		
② 매수인 ② Худалдан авагч	성명(법인명) Овог нэр (Хуулийн этгээдийн нэр)	주민등록번호 (법인·외국인등록번호) Регистрийн дугаар (Хуулийн этгээд / гадаад иргэний бүртгэлийн дугаар)	국적 Иргэншил	
	주소(법인소재지) Хаяг (Хуулийн этгээдийн бүртгэлтэй хаяг)		거래지분 비율 Арилжааны эзлэх хувийн харьцаа (분의) (/)	
	전화번호 Утасны дугаар	휴대전화번호 Гар утасны дугаар		
	③ 법인신고서등 ③ Хуулийн этгээдийн мэдүүлэг гэх мэт	[ ]제출 [ ]별도 제출 [ ]해당 없음 [ ]Ирүүлэх [ ]Тусдаа ирүүлэх [ ]Хамаарахгүй		
	외국인의 부동산등 매수용도 Гадаадын иргэний үл хөдлөх хөрөнгө худалдан авч буй зориулалт	[ ]주거용(아파트) [ ]주거용(단독주택) [ ]Амьдрах зориулалт (Орон сууц) [ ]Амьдрах зориулалт (Хувийн орон сууц) [ ]주거용(그 밖의 주택) [ ]Амьдрах зориулалт (Бусад орон сууц) [ ]레저용 [ ]상업용 [ ]Чөлөөт цаг өнгөрөөх зориулалттай [ ]Арилжааны зориулалт [ ]공업용 [ ]그 밖의 용도 [ ]Үйлдвэрлэлийн зориулалт [ ]Бусад зориулалт		
	위탁관리인 Итгэмжлэгдсэн хариуцагч (국내에 주소 또는 거소가 없는 경우) (Солонгос улсад хаяг болон оршин суух хаяг байхгүй бол)	성명 Овог нэр	주민등록번호 РД	
		주소 Хаяг		
		전화번호 Утасны дугаар	휴대전화번호 Гар утасны дугаар	

<table>
<tr><td rowspan="4">개업
공인중개사
Лицензтэй үл хөдлөх хөрөнгийн агент</td><td colspan="2">성명(법인명)
Овог нэр (Хуулийн этгээдийн нэр)</td><td colspan="2">주민등록번호(법인・외국인등록번호)
Регистрийн дугаар (хуулийн этгээд, гадаад иргэний бүртгэлийн дугаар)</td></tr>
<tr><td colspan="2">전화번호
Утасны дугаар</td><td colspan="2">휴대전화번호
Гар утасны дугаар</td></tr>
<tr><td colspan="2">상호
Нэр</td><td colspan="2">등록번호
Бүртгэлийн дугаар</td></tr>
<tr><td colspan="4">사무소 소재지
Ажлын байрны бүртгэлтэй хаяг</td></tr>
<tr><td rowspan="8">거래대상
Арилжаалагдах зүйл</td><td rowspan="2">종류
Төрөл</td><td colspan="3">④ [ ]토지 [ ]건축물 ( )
[ ]토지 및 건축물 ( )
④ [ ]Газар [ ]Барилга байгууламж ( )
[ ]Газар ба барилга байгууламж ( )</td></tr>
<tr><td>⑤ [ ]공급계약
[ ]전매
⑤ [ ]Нийлүүлэлтийн гэрээ
[ ]Дахин худалдах</td><td>[ ]분양권
[ ]입주권
[ ]Худалдах эрх
[ ]Нүүж оршин суух эрх</td><td>[ ]준공 전
[ ]준공 후
[ ]임대주택 분양전환
[ ]Ашиглалтад орохын өмнө
[ ]Ашиглалтад орсны дараа
[ ]Түрээсийн орон сууцыг худалдах болгон хувиргах</td></tr>
<tr><td rowspan="3">⑥ 소재지/지목/면적
⑥ Бүртгэлтэй хаяг/газрын ангилал/талбай</td><td colspan="3">소재지
Бүртгэлтэй хаяг</td></tr>
<tr><td>지목
Газрын ангилал</td><td>토지면적
Газрын талбай
㎡
м²</td><td>토지 거래지분
Газрын арилжааны хувь
(분의)
(/)</td></tr>
<tr><td>대지권비율
Газрын эрхийн харьцаа
(분의)
(/)</td><td>건축물면적
Барилга байгууламжийн талбай
㎡
м²</td><td>건축물 거래지분
Барилга байгууламжийн арилжааны хувь
(분의)
(/)</td></tr>
<tr><td>⑦ 계약대상 면적
⑦ Гэрээнд хамаарах талбай</td><td>토지 ㎡
Газар м²</td><td colspan="2">건축물 ㎡
Барилга байгууламж м²</td></tr>
<tr><td rowspan="2">⑧ 물건별 거래가격
⑧ Бүтээгдэхүүн тус бүрийн гүйлгээний үнийн дүн</td><td colspan="3">원
вон</td></tr>
<tr><td>공급계약 또는 전매
Нийлүүлэлтийн гэрээ эсхүл дахин худалдах</td><td>분양가격
Худалдах үнэ
원
вон</td><td>발코니 확장 등 선택비용
Тагт өргөтгөх гэх мэт нэмэлт зардал
원
вон</td><td>추가 지급액 등
Нэмэлтээр төлөх дүн
원
вон</td></tr>
<tr><td>⑨ 총 실제 거래가격(전체)
⑨ Нийт бодит арилжааны дүн (Нийт)</td><td>합계
Нийлбэр
원
вон</td><td colspan="3">계약금
Урьдчилгаа төлбөр
원
вон
계약 체결일
Гэрээ байгуулсан огноо

중도금
Дундын төлбөр
원
вон
중도금 지급일
Дундын төлбөр төлөх өдөр

잔금
Үлдэгдэл төлбөр
원
вон
잔금 지급일
Үлдэгдэл төлбөр төлөх өдөр</td></tr>
</table>

<table>
<tr><td rowspan="5">⑩ 종전 부동산
⑩ Нүүж үлдсэн төрийн байгууллагын барилга болон газар бүхий үл хөдлөх хөрөнгө</td><td rowspan="2">소재지/지목/면적
Бүртгэлтэй хаяг/газрын ангилал/талбай</td><td colspan="3">소재지
Бүртгэлтэй хаяг</td></tr>
<tr><td>지목
Газрын ангилал</td><td>토지면적
Газрын талбай
㎡
м²</td><td>토지 거래지분
Газрын арилжааны хувь
(분의)
(/)</td></tr>
<tr><td>대지권비율
Газрын эрхийн харьцаа
(분의)
(/)</td><td>건축물면적
Барилга байгууламжийн талбай
㎡
м²</td><td>건축물 거래지분
Барилга байгууламжийн арилжааны хувь
(분의)
(/)</td></tr>
<tr><td>계약대상 면적
Гэрээнд хамаарах талбай</td><td>토지 ㎡
Газар м²</td><td>건축물 ㎡
Барилга байгууламж м²</td><td>건축물 유형( )
Барилга байгууламжийн хэлбэр ( )</td></tr>
<tr><td rowspan="2">거래금액
Арилжааны үнийн дүн</td><td>합계
Нийлбэр
원
вон</td><td>추가 지급액 등
Нэмэлтээр төлөх дүн
원
вон</td><td>권리가격
Эрхийн үнэлгээ
원
вон</td></tr>
<tr><td>계약금
Урьдчилгаа төлбөр
원
вон</td><td>중도금
Дундын төлбөр
원
вон</td><td>잔금
Үлдэгдэл төлбөр
원
вон</td></tr>
<tr><td colspan="2">⑪ 계약의 조건 및 참고사항
⑪ Гэрээний нөхцөл болон харгалзах зүйлс</td><td colspan="3"></td></tr>
</table>

「부동산 거래신고 등에 관한 법률」 제3조제1항부터 제4항까지 및 같은 법 시행규칙 제2조제1항부터 제4항까지의 규정에 따라 위와 같이 부동산거래계약 내용을 신고합니다.

「Үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тухай хууль」-ийн 3 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэг хүртэл болон тус хуулийг хэрэгжүүлэх журмын 2 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэг хүртэлх журмын дагуу дээр дурдсанаар үл хөдлөх хөрөнгийн арилжааны гэрээний агуулгыг мэдүүлж байна.

년 월 일
он сар өдөр

신고인 Мэдүүлэгч	매도인 : Худалдагч :	(서명 또는 인) (гарын үсэг, тамга)
	매수인 : Худалдан авагч :	(서명 또는 인) (гарын үсэг, тамга)
	개업공인중개사 : (개업공인중개사 중개 시)	
	Лицензтэй үл хөдлөх хөрөнгийн агент : (Лицензтэй үл хөдлөх хөрөнгийн агентаар зуучлуулсан тохиолдолд)	(서명 또는 인) (гарын үсэг, тамга)

시장・군수・구청장 귀하

Хот, сум, дүүргийн засаг дарга танаа

210㎜×297㎜[백상지(80g/㎡) 또는 중질지(80g/㎡)]

(뒤쪽)
(Ард тал)

첨부서류 Хавсаргах баримт бичиг	1. 부동산 거래계약서 사본(「부동산 거래신고 등에 관한 법률」 제3조제2항 또는 제4항에 따라 단독으로 부동산거래의 신고를 하는 경우에만 해당합니다) 1. Үл хөдлөх хөрөнгийн арилжааны гэрээний хуулбар (「Үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тухай хууль」-ийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 4 дэх хэсэгт заасны дагуу дангаар үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тохиолдолд л хамаарна) 2. 단독신고사유서(「부동산 거래신고 등에 관한 법률」 제3조제2항 또는 제4항에 따라 단독으로 부동산거래의 신고를 하는 경우에만 해당합니다) 2. Дангаар мэдүүлэх болсон шалтгаан (「Үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тухай хууль」-ийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 4 дэх хэсэгт заасны дагуу дангаар үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тохиолдолд л хамаарна)

유의사항
Анхаарах зүйлс

1. 「부동산 거래신고 등에 관한 법률」 제3조 및 같은 법 시행령 제3조의 실제 거래가격은 매수인이 매수한 부동산을 양도하는 경우 「소득세법」 제97조제1항・제7항 및 같은 법 시행령 제163조제11항제2호에 따라 취득 당시의 실제 거래가격으로 보아 양도차익이 계산될 수 있음을 유의하시기 바랍니다.

1. 「Үл хөдлөх хөрөнгийн арилжааг мэдүүлэх тухай хууль」-ийн 3 дугаар зүйл, тус хуулийг хэрэгжүүлэх тогтоолын 3 дугаар зүйлд заасан гүйлгээний бодит үнийн дүн нь худалдан авагчийн худалдан авсан үл хөдлөх хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд 「Орлогын албан татварын тухай хууль」-ийн 97 дугаар зүйлийн 1, 7 дах хэсэг, тус хуулийг хэрэгжүүлэх тогтоолын 163 дугаар зүйлийн 11-2 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах үеийн бодит гүйлгээний үнийн дүн гэж үзэн шилжүүлгийн зөрүү ашгийг тооцож болохыг анхаарна уу.

2. 거래당사자 간 직접거래의 경우에는 공동으로 신고서에 서명 또는 날인을 하여 거래당사자 중 일방이 신고서를 제출하고, 중개거래의 경우에는 개업공인중개사가 신고서를 제출해야 하며, 거래당사자 중 일방이 국가 및 지자체, 공공기관인 경우(국가등)에는 국가등이 신고해야 합니다.

2. Гүйлгээний хамаарах талуудын хооронд шууд арилжаа хийх тохиолдолд хамтдаа мэдүүлэгт гарын үсэг эсхүл тамга дарж аль нэг тал нь мэдүүлгийг ирүүлэх ба зуучлуулсан тохиолдолд лицензтэй үл хөдлөх хөрөнгийн агент нь мэдүүлгийг ирүүлэх ёстой бөгөөд аль нэг тал нь тайлангаа улсын болон орон нутгийн засаг захиргаан, төрийн байгууллагын хувьд (улс гэх мэт) улсад тайлагнана.

3. 부동산거래계약 내용을 기간 내에 신고하지 않거나, 거짓으로 신고하는 경우 「부동산 거래신고 등에 관한 법률」 제28조제1항 부터 제3항까지의 규정에 따라 과태료가 부과되며, 신고한 계약이 해제, 무효 또는 취소가 된 경우 거래당사자는 해제 등이 확정된 날로부터 30일 이내에 같은 법 제3조의2에 따라 신고를 해야 합니다.

3. Үл хөдлөх хөрөнгийн арилжааны гэрээний агуулгыг хугацаанд нь мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол 「Үл хөдлөх хөрөнгийн арилжааны тухай хууль」-ийн 28 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэгт заасны дагуу торгууль ногдуулах бөгөөд мэдүүлсэн гэрээг цуцалсан буюу хүчингүй болгосон тохиолдолд арилжаанд хамаарах талууд хүчингүй болсон нь батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус хуулийн 3 дугаар зүйлийн 2-т заасны дагуу мэдүүлэх ёстой.

4. 담당 공무원은 「부동산 거래신고 등에 관한 법률」 제6조에 따라 거래당사자 또는 개업공인중개사에게 거래계약서, 거래대금지급 증명 자료 등 관련 자료의 제출을 요구할 수 있으며, 이 경우 자료를 제출하지 않거나, 거짓으로 자료를 제출하거나, 그 밖의 필요한 조치를 이행하지 않으면 같은 법 제28조제1항 또는 제2항에 따라 과태료가 부과됩니다.

4. Хариуцсан албан хаагч нь 「Үл хөдлөх хөрөнгийн арилжааны тухай хууль」-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу арилжаанд хамаарах талууд болон лицензтэй үл хөдлөх хөрөнгийн агентад арилжааны гэрээ, арилжааны төлбөрийн баримт зэрэг холбогдох материалыг ирүүлэхийг шаардаж болох ба энэ тохиолдолд материалыг ирүүлээгүй эсвэл худал материал ирүүлсэн эсхүл бусад шаардлагатай арга хэмжээ авааагүй бол тус хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх заалт мөн 2 дахь заалтад заасны дагуу торгууль ногдуулна.

5. 거래대상의 종류가 공급계약(분양) 또는 전매계약(분양권, 입주권)인 경우 ⑧ 물건별 거래가격 및 ⑨ 총 실제거래가격에 부가가치세를 포함한 금액을 적고, 그 외의 거래대상의 경우 부가가치세를 제외한 금액을 적습니다.

5. Арилжаанд хамаарах төрөл нь нийлүүлэлтийн гэрээ (худалдан авах) эсхүл дахин худалдах гэрээ (худалдан авах эрх, байранд нүүж орох эрх) бол ⑧ бүтээгдэхүүн тус бүрийн арилжааны үнэ болон ⑨ нийт бодит арилжааны үнэд нэмэгдсэн өртгийн албан татварыг оруулсан дүнг бичиж, түүнээс бусад арилжаанд хамаарах тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татварыг хассан дүнгээр бичнэ.

6. "거래계약의 체결일"이란 거래당사자가 구체적으로 특정되고, 거래목적물 및 거래대금 등 거래계약의 중요 부분에 대하여 거래당사자가 합의한 날을 말합니다. 이 경우 합의와 더불어 계약금의 전부 또는 일부를 지급한 경우에는 그 지급일을 거래계약의 체결일로 보되, 합의한 날이 계약금의 전부 또는 일부를 지급한 날보다 앞서는 것이 서면 등을 통해 인정되는 경우에는 합의한 날을 거래계약의 체결일로 봅니다.

6. “Гэрээ байгуулсан өдөр” гэсэн баганад арилжаанд хамаарах талууд дэлгэрэнгүй онцлон, арилжааны зорилго, болон арилжааны төлбөр зэрэг гэрээний чухал хэсгүүдийн талаар тохиролцсон өдрийг хэлнэ. Энэ тохиолдолд хэлцлийн хамт гэрээний дагуу урьдчилгаа төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн төлсөн бол төлбөрийн огноог арилжааны гэрээ байгуулсан өдөр гэж үзэх ба хэлцэл хийсэн өдөр урьдчилгаа төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн төлсөн өдрөөс өмнө байсан гэдэг нь бичгээр нотлогдох тохиолдолд хэлцэл хийсэн өдрийг арилжааны гэрээг байгуулсан өдөр гэж үзнэ.

작성방법
Бөглөх заавар

1. ①・② 거래당사자가 다수인 경우 매도인 또는 매수인의 주소란에 ⑥의 거래대상별 거래지분을 기준으로 각자의 거래 지분 비율(매도인과 매수인의 거래지분 비율은 일치해야 합니다)을 표시하고, 거래당사자가 외국인인 경우 거래당사자의 국적을 반드시 적어야 하며, 외국인이 부동산등을 매수하는 경우 매수용도란의 주거용(아파트), 주거용(단독주택), 주거용(그 밖의 주택), 레저용, 상업용, 공장용, 그 밖의 용도 중 하나에 √표시를 합니다.

1. ①・② Хэрэв арилжаанд олон тал байгаа бол худалдагч эсхүл худалдан авагчийн хаяг гэсэн баганад ⑥ хамаарах арилжаа тус бүрийн арилжааны эзлэх хувийг үндэслэн тэдгээрийн тус тусын арилжааны эзлэх хувийг (худалдагч болон худалдан авагчийн гүйлгээний эзлэх хувь нь адил байх ёстой) зааж өгч, арилжааны хамаарах талууд хэрэв гадаадын иргэн байх тохиолдолд заавал иргэншлээ бичих ёстой бөгөөд, гадаадын иргэн үл хөдлөх хөрөнгө худалдаж авах тохиолдолд худалдан авах зорилго гэсэн баганад амьдрах зориулалт (Орон сууц), амьдрах зориулалт (Хувийн орон сууц) амьдрах зориулалт (Бусад орон сууц), чөлөөт цаг өнгөрөөх зориулалттай, арилжааны зориулалттай, үйлдвэрийн зориулалттай болон бусад зориулалтуудаас аль нэг дээр √ тэмдэглэнэ үү.

2. ③ “법인신고서등” 란은 별지 제1호의2서식의 법인 주택 거래계약 신고서, 별지 제1호의3서식의 주택취득자금 조달 및 입주계획서, 제2조제7항 각 호의 구분에 따른 서류, 같은 항 후단에 따른 사유서 및 별지 제1호의4서식의 토지취득자금 조달 및 토지이용계획서를 이 신고서와 함께 제출하는지 또는 별도로 제출하는지를 √표시하고, 그 밖의 경우에는 해당 없음에 √표시를 합니다.

2. ③ “Хуулийн этгээдийн мэдүүлэг” гэсэн баганад Хавсралтын 1-2-р маягтын хуулийн этгээд орон сууцны арилжааны гэрээний мэдүүлэг, Хавсралтын 1-3-р маягтын орон сууц худалдан авах санхүүжилт, байранд нүүж орох төлөвлөгөө,Хавсралтын 2-7-р зүйлийн хэсэг тус бүрийн ангиллын дагуух баримт бичиг, тус зүйлийн сүүлийн хэсэгт заасны дагуу Хавсралтын 1-4-р маягтын газар худалдан авах санхүүжилт, газар ашиглах төлөвлөгөөг энэхүү мэдүүлэгтэй хамт ирүүлсэн эсэх мөн тусад нь ирүүлсэн эсэхийг √ тэмдэглэх бөгөөд үүнээс бусад тохиолдолд хамаарахгүй гэсэн хэсэгт √ тэмдэглэнэ үү.

3. ④ 부동산 매매의 경우 “종류” 란에는 토지, 건축물 또는 토지 및 건축물(복합부동산의 경우)에 √표시를 하고, 해당 부동산이 “건축물” 또는 “토지 및 건축물”인 경우에는 ( )에 건축물의 종류를 “아파트, 연립, 다세대, 단독, 다가구, 오피스텔, 근린생활시설, 사무소, 공장” 등 「건축법 시행령」 별표 1에 따른 용도별 건축물의 종류를 적습니다.

3. ④ Үл хөдлөх хөрөнгө худалдах худалдан авах тохиолдолд “Төрөл” гэсэн баганад газар, барилга байгууламж мөн газар ба барилга байгууламж (Цогцолбортой үл хөдлөх хөрөнгийн хувьд)-т √ гэж тэмдэглэх бөгөөд тухайн үл хөдлөх хөрөнгө нь “Барилга байгууламж” болон “Газар ба барилга байгууламж”-ийн хувьд ( ) хэсэгт барилга байгууламжийн төрлийг “Орон сууц, Хотхон, Олон өрхийн, Хувийн, Олон айлын, Ажиллах, амьдрах холимог байр, Орчны амьдрах байгууламж, ажлын өрөө, үйлдвэр” зэрэг 「Барилга байгууламжийн тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоол」-ын Хавсралтын 1-р хүснэгтэд заасны дагуу зориулалт тус бүрээр барилга байгууламжийн төрлийг бичнэ.

4. ⑤ 공급계약은 시행사 또는 건축주 등이 최초로 부동산을 공급(분양)하는 계약을 말하며, 준공 전과 준공 후 계약 여부에 따라 √표시하고, “임대주택 분양전환” 은 임대주택사업자 (법인으로 한정)가 임대기한이 완료되어 분양전환하는 주택인 경우에 √표시합니다. 전매는 부동산을 취득할 수 있는 권리의 매매로서, “분양권” 또는 “입주권”에 √표시를 합니다.

4. ⑤ Нийлүүлэлтийн гэрээ гэдэг нь барилгын ажил гүйцэтгэгч эсхүл барилга өмчлөгчөөс үл хөдлөх хөрөнгийг анх удаа нийлүүлэх (худалдан авах) гэрээг хэлэх бөгөөд уг гэрээ ашиглалтад оруулахаас өмнө эсвэл хойно хийгдсэн эсэхээс хамаарч √ тэмдэглэх бөгөөд “Түрээсийн орон сууцыг худалдах хэлбэрт шилжүүлэх” гэж түрээсийн орон сууцны бизнес эрхлэгч (хуулийн этгээдээр хязгаарлагдана) түрээсийн хугацаа дуусаж худалдах хэлбэрт шилжүүлсэн орон сууцын хувьд √ гэж тэмдэглэнэ. Дахин худалдах гэдэг нь үл хөдлөх хөрөнгө худалдаж авах эрхийг худалдаж худалдан авах явдал бөгөөд "худалдах эрх" эсхүл "байранд нүүж орох эрх" гэсэн хэсэгт √ тэмдэглэнэ үү.

5. ⑥ 소재지는 지번(아파트 등 집합건축물의 경우에는 동・호수)까지, 지목/면적은 토지대장상의 지목・면적, 건축물대장상의 건축물 면적(집합건축물의 경우 호수별 전용면적, 그 밖의 건축물의 경우 연면적), 등기사항증명서상의 대지권 비율, 각 거래대상의 토지와 건축물에 대한 거래 지분을 정확하게 적습니다.

5. ⑥ Бүртгэлтэй хаяг нь газрын дугаар (Орон сууц гэх мэт цогцолбор барилга байгууламжийн хувьд байрны дугаар, тоот)-г, газрын ангилал/талбай нь газрын бүртгэлд байгаа газрын ангилал/ талбай, барилга байгууламжийн бүртгэл дэх барилга байгууламжийн талбай (цогцолбор барилга байгууламжийн хувьд тоот тус бүрээр зориулалтын талбай, бусад барилга байгууламжийн хувьд нийт талбай), бүртгэлийн гэрчилгээ дэх газрын эрхийн харьцаа, арилжаанд хамаарах газар тус бүр болон барилга байгууламжийн арилжааны эзлэх хувийг үнэн зөв бичнэ.

6. ⑦ “계약대상 면적” 란에는 실제 거래면적을 계산하여 적되, 건축물 면적은 집합건축물의 경우 전용면적을 적고, 그 밖의 건축물의 경우 연면적을 적습니다.

6. ⑦ “Гэрээнд хамаарах талбай” баганад арилжааны бодит талбайг тооцож бичих ба барилга байгууламжийн талбай нь цогцолбор барилга байгууламжийн хувьд тухайн зориулалтын талбайг бичиж, бусад барилга байгууламжуудын хувьд шалны нийт талбайг бичнэ.

7. ⑧ “물건별 거래가격” 란에는 각각의 부동산별 거래가격을 적습니다. 최초 공급계약(분양) 또는 전매계약(분양권, 입주권)의 경우 분양가격, 발코니 확장 등 선택비용 및 추가 지급액 등(프리미엄 등 분양가격을 초과 또는 미달하는 금액)을 각각 적습니다. 이 경우 각각의 비용에 부가가치세가 있는 경우 부가가치세를 포함한 금액으로 적습니다.

7. ⑧ “Бараа тус бүрийн арилжааны үнийн дүн” гэсэн баганад үл хөдлөх хөрөнгө тус бүрийн арилжааны үнийн дүнг бичнэ. Анхны нийлүүлэлтийн гэрээ (худалдах) болон дахин худалдах гэрээ (худалдах эрх, байранд нүүж орох эрх) байх тохиолдолд худалдах үнийн дүн, тагтны өргөтгөл зэрэг нэмэлт зардал, нэмэлт төлбөр (Дээд зэрэглэлийн гэх мэт худалдаааны үнээс давсан эсхүл доогуур байгаа үнийн дүн)-г тус бүр бичнэ. Энэ тохиолдолд зардал тус бүрд нэмэгдсэн өртгийн албан татвар багтсан тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татварыг оруулсан дүнгээр бичнэ.

8. ⑨ “총 실제 거래가격” 란에는 전체 거래가격(둘 이상의 부동산을 함께 거래하는 경우 각각의 부동산별 거래가격의 합계 금액)을 적고, 계약금/중도금/잔금 및 그 지급일을 적습니다.

8. ⑨ “Нийт бодит арилжааны үнэ” гэсэн баганад нийт арилжааны үнийг (хоёр ба түүнээс дээш үл хөдлөх хөрөнгө хамт арилжаалсан тохиолдолд үл хөдлөх хөрөнгө тус бүрийн арилжааны үнийн нийлбэр) бичиж, урьдчилгаа төлбөр/дундын төлбөр/үлдэгдэл төлбөр болон тэдгээрийн төлөх огноог бичнэ.

9. ⑩ “종전 부동산” 란은 입주권 매매의 경우에만 작성하고, 거래금액란에는 추가 지급액 등(프리미엄 등 분양가격을 초과 또는 미달하는 금액) 및 권리가격, 합계 금액, 계약금, 중도금, 잔금을 적습니다.

9. ⑩ "Нүүж үлдсэн төрийн байгууллагын барилга газар бүхий үл хөдлөх хөрөнгө" гэсэн баганыг зөвхөн байранд нүүж орох эрхийг худалдах, худалдан авах тохиолдолд бөглөх бөгөөд арилжааны үнийн дүн гэсэн баганад нэмэлт төлбөрийн дүн гэх мэт (Дээд зэрэглэлийн хаш, захиалгын худалдах үнийг давсан болон хэт доогуур үнийн дүн), эрхийн үнийн дүн, нийлбэр дүн, урьдчилгаа, дундын ,үлдэгдэл төлбөрийн дүнг бичнэ.

10. ⑪ “계약의 조건 및 참고사항” 란은 부동산 거래계약 내용에 계약조건이나 기한을 붙인 경우, 거래와 관련한 참고내용이 있을 경우에 적습니다.

10. ⑪ “Гэрээний нөхцөл болон харгалзах зүйлс” гэсэн баганад үл хөдлөх хөрөнгийн гүйлгээний гэрээнд гэрээний нөхцөл эсхүл хугацааг оруулсан тохиолдолд, гүйлгээтэй холбоотой харгалзах агуулга байх тохиолдолд бичнэ.

11. 다수의 부동산, 관련 필지, 매도・매수인, 개업공인중개사 등 기재사항이 복잡한 경우에는 다른 용지에 작성하여 간인 처리한 후 첨부합니다.

11. Хэрэв олон төрлийн үл хөдлөх хөрөнгө, холбогдох тариалангийн талбай, худалдагч/худалдан авагч, лицензтэй үл хөдлөх хөрөнгийн зуучлагч гэх мэтийн мэдээлэл нь төвөгтэй байвал өөр цаасан дээр бичиж тамга дарж зохицуулсны дараа хавсаргана уу.

12. 소유권이전등기 신청은 「부동산등기 특별조치법」 제2조제1항 각 호의 구분에 따른 날부터 60일 이내에 신청해야 하며, 이를 이행하지 않는 경우에는 같은 법 제11조에 따라 과태료가 부과될 수 있으니 유의하시기 바랍니다.

12. Өмчлөх эрхийг шилжүүлэх бүртгэлийн хүсэлтийг 「Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тусгай арга хэмжээний тухай хууль」-ийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт тус бүрийн ангилалд заасан өдрөөс хойш 60 хоногийн дотор гаргах ёстой ба үүнийг биелүүлээгүй тохиолдолд мөн хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу торгууль ногдуулж болох тул анхаарна уу.

처리절차
Шийдвэрлэх шат дараалал

신고서 작성 (인터넷, 방문신고) Мэдүүлэг бөглөх (Интернэтээр, биеэр ирж мэдүүлэх)	→	접수 Хүлээн авч бүртгэх	→	신고처리 Мэдүүлгийг шийдвэрлэх	→	신고필증 발급 Мэдүүлгийн баримт олгох
신고인 Мэдүүлэгч		처리기관: 시・군・구(담당부서) Шийдвэрлэх байгууллага: Хот, сум, дүүрэг (Хариуцсан хэлтэс)				